



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж, үйлчилгээний
төлбөрийн жишиг хэмжээ, журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дугаар заалтууд, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дүгээр заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тоот тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар тоот хамтарсан тушаалуудын үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар, “Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах журам”-ыг гуравдугаар, “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг дөрөвдүгээр, “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтанд үзлэг, шинжилгээ хийх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, түүний гарын үсэг, тамга, тэмдгийн баталгаажилт”-ыг тавдугаар, Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний албаны дарга (Ш.Мөнхцэцэг), Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын дарга (С.Ундрэм), Даатгалын мэргэжилтэн (С.Норовчимэг) нарт даалгасугай.

3. Төлбөрт үйлчилгээний төлбөрийг зохих хууль, журмын дагуу байгууллагын кассаар дамжуулан Төрийн сан дахь дансанд төвлөрүүлэн зохих журмын дагуу зарцуулж, тайлагнаж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байршуулахыг Санхүүгийн албаны дарга (Р.Цэнд-Аюуш)-д хариуцуулсугай.

4. Энэхүү тушаалыг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс мөрдүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний албаны дарга (Ш.Мөнхцэцэг), Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын дарга (С.Ундрэм) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны А/11, А/119 дугаар тоот тушаалуудыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Г.УУГАНЦЭЦЭГ

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн
А/106 дугаар тушаалын 1 хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Баян-Зүрх дүүргийн эрүүл мэндийн төвөөс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй, төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь иргэн бүр шаардлагатай эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг санхүүгийн бэрхшээлгүйгээр авах, эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг бууруулах, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа шууд төлж буй төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэхэд оршино.

1.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасан эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ болон зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамаарч үзүүлэх бөгөөд энэхүү журамд хамаарахгүй.

1.4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөр авч тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Хоёр. Тусламж, үйлчилгээний зохицуулалт

2.1 Байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.

2.2. Лабораторийн тусламж, үйлчилгээний чанарын гадаад хяналтыг үндэсний лавлагаа лабораториор хийлгэх бөгөөд үйлчилгээний төлбөрийг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан байгууллага хоорондын гэрээгээр зохицуулна.

2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.

2.4. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн нийт батлагдсан орны 15 хувиас хэтрэхгүйгээр иргэний хүсэлтийн дагуу тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох бөгөөд тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчид сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.

2.6 Төрөлжсөн мэргэжлийн төвөөс бусад эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлого нь тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн нийт төсвийн 5 хувиас ихгүй байна. Энэхүү төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогод хамтын төлбөрийн орлого хамаарахгүй болно.

2.7 Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй гадаадын иргэнээс энэхүү журмын 1.4-т заасныг баримтлан төлбөр авч тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2.8 Төлбөртэй тусламж, үйлчилгээ авч байсан иргэн өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргасан тохиолдолд холбогдох зөвшөөрлийн хуудсыг бөглүүлж, тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэл үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлсөн төлбөрөөс хасагдуулж тооцон ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр төлбөр тооцоог хийж баримтжуулна. Урьдчилан төлөөгүй тохиолдолд иргэнээс бодит гарсан зардлаар төлбөрийг авна.

2.9 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

2.10 Энэхүү тушаалын 2-р хавсралтад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд: ажлын бус цагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээ, шинжилгээний хариу өгөх, бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, г.м нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.

2.11 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

2.12 Тухайн байгууллагын ажиллагсдын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг бусад эмнэлгийн байгууллагатай хамтын гэрээгээр гүйцэтгүүлнэ.

2.13 Эрүүл мэндийн төвийн захиргаанд бичгээр болон цахимаар ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний урьдчилан сэргийлэх үзлэг, төлбөртэй тусламж үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг үндэслэн үзлэг, шинжилгээний багийг ажиллуулна.

2.14 Аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн хүсэлтээр хийгдэх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний хугацааг харилцан зөвшилцөж хийнэ.

2.15 Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд үзлэг шинжилгээнд ажиллагсдыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажилтанг томилж, орчин нөхцлийн болон бүртгэл судалгааны мэдээлэл зэргийн бэлтгэл хангасан байна.

2.16 Төлбөрийг Төрийн сан банкны 100200320001 дугаар бүхий Эрүүл мэндийн төвийн дансанд 100% шилжүүлсний дараа үзлэг, шинжилгээг эхлүүлнэ.

2.7 Үзлэг шинжилгээгээр халдвартай өвчтэй илэрсэн ажилтнуудыг эмчийн хяналтанд авч эрүүлжүүлэх асуудлыг гэрээний хүрээнд зохион байгуулна.

Гурав. Төлбөрт тусламж үйлчилгээний орлогод тавигдах шаардлага

3.1 Төлбөрт үйлчилгээний орлогыг байгууллагын данс болон, кассанд /кассын машин/ тушаана.

3.2 Эрүүл мэндийн байгууллагын нэр, иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний нэр, төлбөрийн хэмжээ, төлсөн дүн, тусламж үзүүлсэн эмчийн нэр, огноог тэмдэглэсэн баримтыг иргэдэд олгоно.

3.3 Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтан аливаа төлбөрт үйлчилгээний тооцоог үйлчлүүлэгчтэй шууд хийхийг хатуу хориглоно.

Дөрөв. Бусад

4.1 Үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

4.2 Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээнээс төлбөр авсан нь иргэний гомдлын мөрөөр, хөндлөнгийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно.

4.3 Энэхүү тушаалын хавсралтаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын тушаалаар батлахгүй бөгөөд зайлшгүй шаардлагаар шинэ технологи, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тусламж, үйлчилгээ нэмэгдэх бол Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох мэдээллийг албан бичгээр ирүүлж, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж болно.

4.4 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, цалин, хөлс, урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нөлөөллийг тооцож Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухай бүр шинэчилж мөрдөнө.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
 А/106 дугаар тушаалын 2 хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ,
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хэлбэр	Код	ЭМД-ын багцад хамаарах эсэх	Төлбөрийн жишиг хэмжээ
1.	Эмчийн үзлэг	Анхан болон давтан үзлэг тус бүрдээ		Тийм	15,000
Багажийн шинжилгээ					
2.	Багажийн шинжилгээ	Зүрхний цахилгаан бичлэг	10201005	Тийм	10,000
3.	Багажийн шинжилгээ	Умайн хүзүүний дуран /кольпоскопи/	10201008	Тийм	30,000
4.	Дуу авианы шинжилгээ	Аудиометрийн шинжилгээ	10220008	Тийм	22,000
Хэт авиан оношилгоо					
5.	Бүх төрлийн Хэт авиан оношилгоо	Хэт авиан /зүрх, бамбай булчирхай, хөх, захын судас, нүд, хэвлий, нярайн түнх, нярайн зулай, цээж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхтэн, гүрээний артери, зөөлөн эд, шөрмөс, үе, тархины судасны доплер, тархины судасны дуплекс/	10203002	Тийм	20000
6.	Бүх төрлийн уян дурангийн оношилгоо	Уян дуран /Бүдүүн гэдэс, уушги, улаан, хоолой, ходоод, төвөнх/	10202003	Тийм	60,000
7.	Бүх төрлийн уян дурангийн оношилгоо	Дурангийн хэт авиан оношилгоо /EUS/ 12 хуруу гэдэсний дуран	10202001	Тийм	550,000
8.	Бүх төрлийн уян дурангийн оношилгоо	Унтуулгатай уян дуран/Бүдүүн гэдэс, уушги, улаанхоолой, төвөнх/	10202002	Тийм	100,000
Дижитал рентген					
9.	Рентген байрлал оношилогоо-1	/Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, далөвчүү, ухархай, хавирга, чих эгэм, эрүү/	10214002	Тийм	10,000

10.	Рентген оношилогоо-2 байрлал	/Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, далөвчүү, ухархай, хав ирга, чих эгэм, эрүү/	10214003	Тийм	20,000
11.	Рентген харалт	Цээж хэвлий	10214006	Тийм	10,000
Нүдний үзлэг					
12.	Эвэрлэг, салстаас гадны биет авах	Ажилбар		Тийм	270,000
13.	Өвдөг нээх	Нүдний даралт хэмжих		Тийм	230,000
14.	Нүдний оношилогоо шинжилгээ	G Probe	10223001	үгүй	50,000
15.	Нүдний оношилогоо шинжилгээ	A, B скайн	10223002	үгүй	20,000
16.	Нүдний оношилогоо шинжилгээ	Нүдний оптикал кохерент томограф	10223003	Үгүй	120,000
17.	Нүдний оношилогоо шинжилгээ	Нүдний өнцөг нээх лазер /ЛПИ/	10223004	Үгүй	120,000
Чих хамар хоолойн үзлэг					
18.	Чих дурандах	Багажийн үзлэг	10202004	30,000	30,000
19.	Чих угаах	Ажилбар		Үгүй	15,000
20.	Гайморын хөндийн угаалга 1 талд	Ажилбар		Үгүй	25,000
21.	Гайморын хөндийн угаалга 2 талд	Ажилбар		Үгүй	45,000
22.	Төвөнхийн эмчилгээ эм цацах	Ажилбар		Үгүй	1 удаа 5,000
23.	Залгиур орчмын буглаа нээх /бусад буглаа/	Ажилбар		Үгүй	30,000
24.	Хамрын шинэ гэмтэл засах	Ажилбар		Үгүй	80,000
25.	Хамрын өмнөд чихээс	Ажилбар		Үгүй	20,000
26.	Сэтэрхий чих оёх (2 тал)	Ажилбар		Үгүй	1 тал 35,000 2 тал 70,000
27.	Чих цоолох	Ажилбар		Үгүй	10,000
28.	Хамар, чихнээс гадны биет авах	Ажилбар		Үгүй	10,000
Эмэгтэйчүүд					
29.	Кольпоскопи, цууны хүчлийн сорил тавих	Багажийн үзлэг ажилбар	10201008	30,000	30,000
30.	Ерөндөг авах, тавих үзлэг	Ажилбар			25,000
31.	Ургацаг авах	Ажилбар	10201023	10,000	10,000
32.	Мазок	Ажилбар			10,000
33.	Эсийн шинжилгээ	Ажилбар			30,000
34.	Суулгац авах. тавих	Ажилбар	Үйлчлүүлэгч суулгацаа авчирсан тохиолдолд	өөрөө	Тавих-70,000 Авах-50,000

35.	Суулгац авах тавих	Ажилбар	Тухайн байгууллагаас гаргасан тохиолдолд	Тавих120,000 Авах-50,000
36.	Үзлэг	Ажилбар		25,000
Гэмтэл, мэс засал				
37.	Боолт хийх, оёдол авах, шарханд эм цацах, цэвэрлэх	Ажилбар		Тийм 20,000
38.	Гоо сайхны оёдол	Ажилбар		Тийм 30,000
39.	Шигдсэн хумс авах	Ажилбар		Тийм 15,000
40.	Гипс авах, тавих тус бүр	Ажилбар		Тийм 10,000
41.	Хэвтрийн өвчтөнд гэрээр очиж үйлчлэх	Ажилбар		Тийм 20,000
42.	Цэвэр боолт	Ажилбар	1 удаагийнх	10,000
43.	Бохир боолт	Ажилбар	1 удаагийнх	15,000
44.	Хатиг, арьсан дорхи буглаа нээх	Ажилбар		Тийм 25,000
45.	Шарханд анхдагч хоёрдогч цэгцлэлт хийх	Ажилбар		Тийм 20,000
46.	Өөхөн хавдар авах /5см хүртэл/	Ажилбар		Тийм 40,000
Мэдрэл				
47.	Толгойн өвдөлт намдаах мигрен	Эмчилгээ		Тийм 15,000
48.	Тархины цус харвалтын дараах өвдөлт намдаах	Эмчилгээ		Тийм 10,000
49.	Гурвалсан мэдрэлийн өвдөлт намдаах	Эмчилгээ		Тийм 15,000
50.	Гурвалсан мэдрэлийн өвдөлт эмийн эмчилгээний хориг хийх	Эмчилгээ		Тийм 10,000
51.	Хүзүүний булчингийн өвдөлт намдаах	Эмчилгээ		Тийм 10,000
52.	Өвдөгний өвдөлт намдаах	Эмчилгээ		Тийм 50,000
53.	Ууцны хориг тавих	Эмчилгээ		Тийм 10,000
54.	Могойн яр өвчний өвдөлт намдаах	Эмчилгээ		Тийм 15,000
Физик эмчилгээ				
55.	УВЧ	Шарлага	1 удаагийнх	2,000
56.	Импра улаан туяа	Шарлага	1 удаагийнх	2,000
57.	Электрофореза	Шарлага	1 удаагийнх	2,000
58.	Лазер	Шарлага	1 удаагийнх	2,000
59.	Нурууны, хүзүүний татлага	Багажийн эмчилгээ	1 удаагийнх	10,000
Уламжлалт эмчилгээ				
60.	Цахилгаан зүү	Эмчилгээ		Тийм 15,000
61.	Зүүн эмчилгээ	Эмчилгээ		Тийм 10,000
62.	Самнуур	Ажилбар		Тийм 40,000
63.	Бичил хануур	Ажилбар		Тийм 10,000
64.	Төөнүүр	Ажилбар		Тийм 5,000
65.	Бариа засал хэсэгчилсэн бариа тус бүр/	Уламжлалт засал		Тийм 10,000
66.	Бумба тавих	Уламжлалт засал		Тийм 10,000
67.	Зүү төөнүүр	Уламжлалт засал		Тийм 15,000
68.	Зегийн балтай татлага	Уламжлалт засал		Тийм 10,000

Шүдний эмчилгээ					
69.	Амны хөндийн үйлчилгээ	Бүх шүдний өнгөлгөө	10401005	үгүй	15,000
70.	Амны хөндийн үйлчилгээ	Голонцортой шүд хийх	10401006	үгүй	30,000
71.	Амны хөндийн үйлчилгээ	Силант хийх	1041008	Үгүй	15,000
72.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Бүх шүдний өнгөлгөө хийх	10401005	Үгүй	15,000
73.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Голонцортой шүд хийх	10401006	үгүй	30,000
74.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Силант хийх	1041008	үгүй	15,000
75.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Сувгын эмчилгээ-1 сурвалжтай	Сүүн	Тийм	20,000
76.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Сувгын эмчилгээ2сурвалжтай	Сүүн	Тийм	35,000
77.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Сувгын эмчилгээ-3 сурвалжтай	Сүүн	Тийм	48,000
78.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Сувгын эмчилгээ-1 сурвалжтай	Байнгын	Тийм	25,000
79.	Шүдний өвчний	Сувгын эмчилгээ-2	Байнгын	Тийм	35,000
80.	Үзлэг оношилгоо,эмчилгээ	Сурвалжтай			
81.	Шүдний өвчний үзлэг оношилгоо,эмчилгээ	Сувгын эмчилгээ-3 сурвалжтай	Байнгын		
82.	Шүдний эргэн тойрон эдийн эмчилгээ	Шүдний чулуу түүх		Тийм	20,000
83.	Шүдний эргэн тойрон эдийн эмчилгээ	Хатуу эд лак,гель түрхэх		Тийм	5000
84.	Шүд буйлны мэс ажилбар	Байнгын шүд авах		Тийм	25,000
85.	Шүд буйлны мэс ажилбар	Сүүн шүд авах		Тийм	15,000
86.	Шүд буйлны мэс ажилбар	Агт араа		Тийм	30,000
87.	Цоорлын эмчилгээ	Сүүн шүд-өнгөц			15,000
88.	Цоорлын эмчилгээ	Сүүн шүд-Дунд		Тийм	20,000
89.	Цоорлын эмчилгээ	Сүүн шүд-гүн		Тийм	25,000
90.	Цоорлын эмчилгээ	Байнгын шүд-өнгөц		Тийм	20,000
91.	Цоорлын эмчилгээ	Байнгын шүд-дунд		Тийм	25,000
92.	Цоорлын эмчилгээ	Байнгын шүд-Гүн		Тийм	30,000
93.	Цоорлын эмчилгээ	Тариа		Тийм	35,000

Лабораторийн шинжилгээ					
Цусны ерөнхий шинжилгээ					
№	Үйлчилгээний нэр төрөл	Код	Үйлчилгээний төрөл	ЭМД-ын багцад хамаарах эсэх	өлбөрийн жишиг хэмжээ
94.	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	10104008	21Үзүүлэлт	Тийм	14000
95.	Цусны бүлэг, резус фактор	10105044	2 Үзүүлэлт	Тийм	11000
96.	УЭТХ (СОЭ)	10104005	1 Үзүүлэлт	Тийм	4500
97.	Цусны хувийн тохироо тодорхойлох	10105046	1 Үзүүлэлт	Тийм	15000
Биохимийн шинжилгээ					
98.	Цусанд сахар тодорхойлох	10102021	1 Үзүүлэлт	Тийм	3000
99.	Амилаза	10102006	1 Үзүүлэлт	Тийм	5000
100	Креатинин	10102033	1 Үзүүлэлт	Тийм	4000
101	Мочевин /шээг/	10102052	1 Үзүүлэлт	Тийм	4000
102	Шүлтлэг фосфотаза	10102086	1 Үзүүлэлт	Тийм	4000
103	Холестерин	10102081	1 Үзүүлэлт	Тийм	3000
104	Уураг /нийт/	10102057	1 Үзүүлэлт	Тийм	3000
105	Альбумин	10102004	1 Үзүүлэлт	Тийм	3000
106	АЛАТ	10102003	1 Үзүүлэлт	Тийм	3000
107	АСАТ	10102010	1 Үзүүлэлт	Тийм	3000
108	Билирубин /нийт/	10102013	1 Үзүүлэлт	Тийм	8000
109	Билирубин /шууд/	10102014	1 Үзүүлэлт	Тийм	3000
110	Билирубин /шууд бус/	10102015	1 Үзүүлэлт	Тийм	3000
111	Натри /Na/	10102055	1 Үзүүлэлт	Тийм	5000
112	Кали /K/	10102028	1 Үзүүлэлт	Тийм	5000
113	Хлор /Cl/	10102079	1 Үзүүлэлт	Тийм	5000
114	Кальци /Ca/	10102030	1 Үзүүлэлт	Тийм	4000
115	Төмөр	10102070	1 Үзүүлэлт	Тийм	4000
116	Фосфор	10102075	1 Үзүүлэлт	Тийм	3000
117	Магни	10102048	1 Үзүүлэлт	Тийм	4000
118	Триглицерид	10102072	1 Үзүүлэлт	Тийм	3000
119	HDL /ИНЛП/	10102027	1 Үзүүлэлт	Тийм	6000
120	LDL /БНЛП/	10102011	1 Үзүүлэлт	Тийм	10000
121	Креатинфосфокиназа MB	10102037	1 Үзүүлэлт	Тийм	10000
122	ASLO/ ASO (тоогоор)	10102009	1 Үзүүлэлт	Тийм	10000
123	CRP (тоогоор)	10102067	1 Үзүүлэлт	Тийм	11000
124	RF /тоогоор/	10102066	1 Үзүүлэлт	Тийм	9000
125	ГГТ	10102018	1 Үзүүлэлт	Тийм	3000
126	ЛДГ	10102043	1 Үзүүлэлт	Тийм	4000
127	Липаза	10102046	1 Үзүүлэлт	Тийм	6000
128	HbA1c /глюкозожсон гемоглобин/	10106112	1 Үзүүлэлт	Тийм	17000
129	UA /шээсний хүчил/	10102091	1 Үзүүлэлт	Тийм	3000
130	ASLO, CRP, RF		3 Үзүүлэлт	Тийм	30000

131	ASLO, CRP, RF/түргэвчилсэн тест/	10106121	3 Үзүүлэлт		30000
132	Үтрээний наацын шинжилгээ	10113014	11 Үзүүлэлт	Тийм	13000
133	Цусны хийн шинжилгээ	10113017		Тийм	28000
Иммуногематологийн шинжилгээ					
134	Шээсний ерөнхий шинжилгээ	10113019	12 Үзүүлэлт	Тийм	10000
135	Цагаан хорхой/натив харах/	10110013	1 Үзүүлэлт	Тийм	5000
136	Нян тээгчийн шинжилгээ /бацил илрүүлэх/	10101004		Тийм	30000
137	Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх Грамын будгийн арга	10101005		Тийм	10000
138	Цэрэнд ВК тодорхойлох	10101007		Тийм	15000
139	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ /шарх, хамар залгиур, залгиур, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, шээс, гуурсны арчидас, хатгалтын шингэн, цэр, бронхи угаадас/	10101003		Тийм	32000
140	Мөөгөнцөр илрүүлэх	10101002		Тийм	28000
141	Микобактери илрүүлэх болон РИФ тэсвэржилт тодорхойлох	10101001		Тийм	35000
142	Цусны ариун чанар тодорхойлох	10101008		Тийм	72000
143	Vitek/ АМЧ, үүсгэгч илрүүлэх/	10101001		Тийм	35000
Иммунологийн шинжилгээ					
144	HBs Ag /тоогоор/	10106203	1 Үзүүлэлт	Тийм	15000
145	Anti HCV /тоогоор/	10106153	1 Үзүүлэлт	Тийм	25000
146	AFP	10106230	1 Үзүүлэлт	Тийм	20000
147	CEA	10106098	1 Үзүүлэлт	Тийм	22000
148	T3	10106164	1 Үзүүлэлт	Тийм	15000
149	T4	10106161	1 Үзүүлэлт	Тийм	17000
150	TSH	10106158	1 Үзүүлэлт	Тийм	17000
151	H.Pylori IgG, IgM	10106045	1 Үзүүлэлт	Тийм	30000
152	Vit D /25-оН/	10106108	1 Үзүүлэлт	Тийм	36000
153	Anti TPO	10106157	1 Үзүүлэлт	Тийм	30000
154	Anti TG	10106160	1 Үзүүлэлт	Тийм	20000

155	Total PSA	10106169	1 Үзүүлэлт	Тийм	21000
156	Ca125	10106141	1 Үзүүлэлт	Тийм	25000
157	Ca15-3	10106209	1 Үзүүлэлт	Тийм	35000
158	Ca72-4	10106026	1 Үзүүлэлт	Тийм	35000
159	Ca19-9	10106207	1 Үзүүлэлт	Тийм	30000
160	fT3	10106218	1 Үзүүлэлт	Тийм	20000
161	fT4	10106217	1 Үзүүлэлт	Тийм	15000
162	HBs Ag / cassette /	10106204	1 Үзүүлэлт	Тийм	6000
163	Anti HCV cassette /	10106206	1 Үзүүлэлт	Тийм	6000
164	T3,T4,TSH/бамбайн гормон/		3 Үзүүлэлт	Тийм	49000
165	AntiHBs	10106101	1 Үзүүлэлт		25000
166	DOX /HIV cassette/	10106116	1 Үзүүлэлт	Тийм	6000
167	TPHA	10106172	1 Үзүүлэлт	Тийм	5000
168	(Syphilis TP-IgG) ELISA	10106177	1 Үзүүлэлт	Тийм	15000
169	ХДХВ/ ДОХ илрүүлэг ELISA	10106196	1 Үзүүлэлт	Тийм	25000
170	RPR /хурдавчилсан реаген тест/	10106210	1 Үзүүлэлт	Тийм	8000
171	АМЧ	10106087		Тийм	20000
172	Иммуноглобулин G	10106124	1 Үзүүлэлт	Тийм	11000
173	Иммуноглобулин M	10106126	1 Үзүүлэлт	Тийм	11000
174	Иммуноглобулин A	10106126	1 Үзүүлэлт	Тийм	11000
175	Тропонин / хурдавчилсан тест cassette/	10106167	1 Үзүүлэлт	Тийм	25000
Цус бүлэгнэлтийн шинжилгээ коагулограмм					
176	APTT	10109001	1 Үзүүлэлт	Тийм	5000
177	Fibrinogen	10109005	1 Үзүүлэлт	Тийм	6000
178	ТТ	10109012	1 Үзүүлэлт	Тийм	5000
179	PT(INR)	10109019	2 Үзүүлэлт	Тийм	5000
180	D-Dimer	10109004	1 Үзүүлэлт	Тийм	60000
Молекул биологийн PCR-ийн шинжилгээ					
181	HBV-DNA/ В вирус тоолох/	10108031	1 Үзүүлэлт	Тийм	133000
182	HCV-RNA/ С вирус тоолох/	10108035	1 Үзүүлэлт	Тийм	120000
183	HDV-RNA/ Д вирус тоолох/	10108033	1 Үзүүлэлт	Тийм	163000
184	HCV-ийн генотипийг тодорхойлох	10108034	3 Үзүүлэлт	Тийм	120000
185	Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэг	10108006	12 Үзүүлэлт	Тийм	150000
186	Микоплазмын ДНХ илрүүлэх	10108008	2 Үзүүлэлт	Тийм	50000
187	Нейссерия гонореи ДНХ илрүүлэх	10108009	1 Үзүүлэлт	Тийм	110000

188	Трихомонад илрүүлэх ДНХ	10108015	1 Үзүүлэлт	Тийм	63000
189	Уреаплазмын илрүүлэх ДНХ	10108017	2 Үзүүлэлт	Тийм	50000
190	Фемофлор илрүүлэх ДНХ	10108018		Тийм	85000
191	Хламид илрүүлэх ДНХ	10108021	1 Үзүүлэлт	Тийм	63000
192	HPV-DNA генотип) (16,18)	10108026	2 Үзүүлэлт	Тийм	60000
193	CMV-DNA илрүүлэх	10108029	2 Үзүүлэлт	Тийм	121000
194	Ковиде19/SARS CoV2/ PHX	10108007			35000

Цитологийн шинжилгээ

195	Умайн хүзүүний эсийн шинжилгээ			Тийм	35000
196	PAPP-A	10106065		Тийм	30000

Урьдчилан сэргийлэх үзлэг

197	Урьдчилан сэргийлэх, илрүүлэх мэндийн гаргах зөвлөгөө өгөх эрт эрүүл дүгнэлт	Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	11110001	Үгүй	Гэрээний үнийн дүнгээр
198		Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах	11101003	Үгүй	30,000
199		Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилогоо шинжилгээнд хамрагдах	11101003	Үгүй	50,000
200		Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах	11101004	Үгүй	30,000
201		Төрийн албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэг		Үгүй	30,000
202		Гадаадын харьяатын урьдчилан сэргийлэх үзлэг		Үгүй	50,000
203		Цэцэрлэг, яслийн үзлэг		Үгүй	10,000
204		Жолооны үнэмлэх авах зорилгоор	11101005	Үгүй	30,000

205	Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан, ажиллагсад	6 сар тутамд	Үгүй	40,000
		Ус хангагч байгууллагын ус түгээгч, усан сан ариутгагч, усны машины жолооч	6 сар тутамд	Үгүй	20,000
		Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш болон хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч	Хичээлийн жил эхлэхээс 30 хоногийн дотор	Үгүй	20,000
		Хүүхдийн зуслангийн багш	Үйл ажиллагаа эхлэхээс 30 хоногийн дотор	Үгүй	10,000
		Хүүхдийн асрамж, халамжийн газрын багш, туслах багш	Жилд 1 удаа	Үгүй	10,000
		Ерөнхий боловсролын сургуулийн 1-5ангийн багш, дотуур байрны болон өдөр өнжүүлэх бүлгийн багш	Хичээлийн жил эхлэхээс 30 хоногийн дотор	Үгүй	10,000
		Үсчин, гоо сайханч	Жилд 1 удаа	Үгүй	15,000
		Усан бассейны багш, дасгалжуулагч, аврагч	Жилд 1 удаа	Үгүй	20,000
		Зочид буудлын үйлчлэгч, сауны газрын иллэгийн ажилтан	Жилд 1 удаа	Үгүй	15,000
		Эмийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан	6 сар тутам	Үгүй	40,000
Эмийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд оролцдог бусад эм, хэрэгсэлтэй харьцаж ажиллагсад	Жилд 1 удаа	Үгүй	15,000		

		оролцдог оос бусад эм, хэрэгсэлтэй харьцаж ажиллагсад			
Нэмэлт үйлчилгээ					
206	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ /Люкс/	31401004	Үгүй	40000
207	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ /хагас люкс	31401005	Үгүй	30000
208	Нэмэлт үйлчилгээ	Шарил тээвэрлэх/1км-т	31402002	Үгүй	3000/км
209	Нэмэлт үйлчилгээ	Тээвэрлэх үйлчилгээ /1км-т яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд/		Үгүй	2000
210	Нэмэлт үйлчилгээ	Шарил хадгалах үйлчилгээ	31402001	Үгүй	28,000
211	Нэмэлт үйлчилгээ	Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1км-т яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд	31402001	Үгүй	2000
212	Сэтгэц зан үйлийн эмгэгийн тусламж үйлчилгээ	Бүх төрлийн сэтгэл засал /ганцаарчилсан, гэр бүлийн, хосын, өөрийгөө удирдах/	10801001	Үгүй	30,000
213	Арьсны, салстын эмчилгээний гоо заслын тусламж үйлчилгээ	Арьсны хоргүй хавдар, үү, ургацаг авах /байрлал хэмжээнээс хамаарч олон тооны жижиг хэмжээтэй бол/	11201002	Үгүй /багаж/	50,000
214	Арьсны, салстын эмчилгээний гоо заслын тусламж үйлчилгээ	Том хэмжээтэй үү, ургацаг авах	11201023	үгүй	10,000

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
А/106 дугаар тушаалын 3 хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ ОЛСОН ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн жишиг хэмжээ, жагсаалтад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй, код, ангиллыг өөрчлөхгүйгээр үйлчилгээний хүрээнд тохируулан батална.

1.3 Нэмэлт тусламж, үйлчилгээ гэдэгт Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.4 Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасныг тус тус ойлгоно.

1.4 Энэ журам нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 болон 15.2-т зааснаас бусад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад хамаарна.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогын бүртгэл, зарцуулалт

3.1 Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх үүргийн хүрээнд захиран зарцуулна.

3.2 Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд зарцуулна.

3.3 Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллага нь тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, шинээр бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46.2-т заасан журмын дагуу зарцуулж, тайлагнана.

3.4 Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлбөр төлөх бүхий л төрлийн боломжоор хангаж төлбөрийг төрийн сан дахь төсвийн үндсэн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлнэ.

3.5 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана.

3.6 Эрүүл мэндийн байгууллага нь иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

3.7 Энэ журамд заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогын зарцуулалтын жилийн эцсийн тайланг дараа жилийн төсвийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Дөрөв. Эмч, эмнэлгийн ажилтны хориглох зүйл

4.1 Эмч, эмнэлгийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

4.1.1 Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх;

4.1.2 Эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх;

4.1.3 Үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах

Тав. Хяналт

5.1. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар хүлээнэ.

5.2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд эрүүл мэндийн байгууллагын дотоод аудитын нэгж улирал бүр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын нэгж жилд нэг удаа хяналт-шинжилгээ, унэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

5.3. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын дарга, захирал нар хангаж ажиллана.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
А/106 дугаар тушаалын 4 хавсралт

**“ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ”**

1.1 Энэхүү журам нь Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ оношлогоо үйлчилгээг төлбөртэй үзүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Төлбөртэй тусламж үйлчилгээ гэдэгт энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хамаарна.

1.3 Эрүүл мэндийн төвийн захиргаанд албан бичгээр болон цахимаар ирүүлсэн байгууллага аж ахуйн нэгж, иргэний урьдчилан сэргийлэх үзлэг, төлбөртэй тусламж үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг үндэслэн үзлэг шинжилгээний багийг ажиллуулна.

1.4 Аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн хүсэлтээр хийгдэх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний хугацааг харилцан зөвшилцөж хийнэ.

1.5 Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн бүртгэлийн дугаарыг тэмдэглэн, багийн ахлагч эмчийн тамга дарж баталгаажуулна.







1.6 Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд үзлэг шинжилгээнд ажиллагсдыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажилтанг томилж орчин нөхцөлийн болон бүртгэл судалгааны мэдээлэл зэргийн бэлтгэл хангасан байна.

1.7 Төлбөрийг Төрийн сангийн банкны 100200320401 дугаар бүхий Эрүүл мэндийн төвийн дансанд 100% шилжүүлсний дараа үзлэг шинжилгээг эхлүүлэх ба сургууль цэцэрлэгийн багшаас бусад ажилчидын үзлэг шинжилгээний зардлыг үзлэг шинжилгээ хийгдсэний дараа тухайн байгууллагуудаас нэхэмжлэн авна.

1.8 Үзлэг шинжилгээгээр халдвартай өвчтэй илэрсэн ажилтнуудыг хяналтанд авч эрүүлжүүлэх асуудлыг гэрээний хүрээнд зохион байгуулна.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн
 А/106 дугаар тушаалын 6 хавсралт

“ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАНД ҮЗЛЭГ,
 ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, ТҮҮНИЙ ГАРЫН ҮСЭГ,
 ТАМГА, ТЭМДГИЙН БАТАЛГААЖИЛТ”

№	Үзлэг, шинжилгээний нэр төрөл	Поликлиник	
1	Сүрьеэ:/Флюорограф (рентген)	Ж.Хуягандорж  Дүрс оношлогооны эмч В.Цэнгэмаа  Б.Булгантуяа  Дүрс оношлогооны эмч	Рентген техникч Д.Эрдэнэ  Х.Баасанбат  А.Мишигдорж 
2	Арьсны халдварт өвчнүүд	Э.Нарантуяа Л.Баярмаа  Б.Бямбасүрэн	
3	Цагаан хорхой илрүүлэх Хамар залгиурын арчдас /эмгэг төрөгч илрүүлэх/ Бактериологи /нян тээгч илрүүлэх/	Нян судлагч их эмч Ө.Дэмбэрэлжаргал  Нян судлагч их эмч Э.Ариунгэрэл Нян судлагч их эмч Б.Буяндэлгэр 	Лаборант Г.Жагдаг Б.Нямцэцэг  Ө.Бахатбек
4	Баталгаажуулалт /тамга ,гарын үсэг/	Эрхлэгч Ч.Отгонбаяр	Орлогч Д.Оюун  

		<p>Г.Мөнхтуяа</p> <p>Р.Энхтайван</p> 	<p>Д.Цолмон</p> <p>Н.Мягмарсүрэн</p> <p>С.Пүрэвсан</p>  <p>Б.Болормаа</p> <p>Л.Энхтуул</p> 
--	--	---	--

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
 2022 оны 08 дугаар сарын 05...-ны өдрийн
 А/1106 дугаар тушаалын 6...хавсралт

ЭРТ ИЛРҮҮЛЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН ЯВЦАД ХЯНАЛТ,
 ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ ХИЙХ АЛБАН ТУШААЛТАН	Хугацаа														
			I улирал			II улирал			III улирал			IV улирал					
1.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн Эрүүл мэндийн дэвтрийн хяналт хийх	Халдварын хяналт, сэргийлэлт хариуцсан халдвар судлаач			+			+						+			+
2.	Урьдчилан сэргийлэх шинжилгээний лабораторийн журнал, үзлэгийн дэвтрийн дугаарлалтанд хяналт хийх	Халдварын хяналт, сэргийлэлт хариуцсан халдвар судлаач			+			+						+			+
3.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн лабораторийн шинжилгээ хийгдэж байгаа байдалд хяналт хийх	Лабораторийн эрхлэгч Чанарын алба	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
4.	Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөл, эрүүлжилтийн байдалд хяналт хийх	Чанарын алба									+						+
5.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн тайлан, үр дүнд хяналт, үнэлгээ хийх	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	+		+						+				+	+	
6.	Эрт илрүүлэгийн санхүүгийн тооцоонд хяналт хийх		+		+						+				+	+	
7.	Эм эмнэлгийн хэрэгслийн захиалга, зарцуулалтанд хяналт хийх	Эм зүйн алба	+		+	+			+	+		+	+		+	+	+